

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2021.05.05 № 1403  
танай -ны № -т

## Г Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд оролцоо нэр дэвшигчээс ирүүлсэн мөрийн хөтөлбөрийг холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагад нийцсэн эсэхийг хяналаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд оролцох нэр дэвшигч нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцүүлэн сонгуулийн мөрийн хөтөлбөрөө боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг Төрийн аудитын байгууллагад ирүүлж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Үндэсний аудитын газар нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд оролцох нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль тогтоомж холбогдох бусад баримтыг тус шалгуур болгон авч үзсэн.

## Дүгнэлт

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд нэр дэвшигч Ухнаагийн Хүрэлсүхийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2, 33.4. дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлага, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тус тус нийцсэн байна.

Мөрийн хөтөлбөр /.....<sup>14</sup>..... хуудас/-ийг хавсаргав.

Хүндэтгэсэн,



Д.ЗАНДАНБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 2021 ОНЫ  
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД МОНГОЛ АРДЫН НАМААС  
НЭР ДЭВШИГЧИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



**2021 он**

## НЭГ. ШУДАРГА ЁС

### 1.1. ХАРИУЦЛАГАТАЙ ТӨР – ШУДАРГА НИЙГЭМ

“Чин шударгууг зарчим болгоно  
Чингис хааныхаа зарлигийг ёс болгоно”

#### Хүний эрхийг дээдэлсэн нийгэм

1.1.1. Хүний эрх, эрх чөлөөг хангах тогтолцоог бэхжүүлэн, зөрчлийг зогсоож эрхийг сэргээх ажлыг тууштай дэмжинэ. Хүний эрхийн асуудлаар төрийн болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хувийн хэвшлийн оролцоог өргөтгэн, иргэдийн санаачилгыг дэмжин ажиллана.

1.1.2. Хүний эрх, эрх чөлөөг ноцтой зөрчсөн эрүүдэн шүүлт, дарамт шахалтыг тасалж, хэлмэгдлээс анgid байх зарчмыг чанд баримтлан хүний эрхийг тууштай хамгаална.

1.1.3. Хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдаж байгаа эсэх асуудлаар шийдвэр гаргах, шийдвэр нь бүрэн хэрэгждэг байх чиглэлээр хууль эрх зүйн орчин бүрдүүлнэ.

#### Ардаа алагчилдаггүй төр

1.1.4. Төрийн албан дахь танил тал, намын харьялал, хамаатан садан, хувь хүн, нийгмийн тодорхой бүлэгт давуу байдал олгодог байдлыг таслан зогсоож, хууль алагчлалгүй үйлчлэх, хүн биш хууль засагладаг зарчмыг чандлан хэвшүүлнэ.

#### Сонгодог парламентын ардчилал

1.1.5. Ардчилсан засаглалыг улам бэхжүүлж, ард түмний төлөөллийг хангах, ил тод, нээлттэй тайлагнадаг, үр өгөөжтэй байх зарчмыг хэвшүүлнэ.

1.1.6. Улс төрийн дарангуйлал, дүр эсгэсэн ардчиллаас анgid байж, ардчиллын шалгуур үзүүлэлтийг ахиулан, сонгодог парламентын засаглалыг төгөлдөржүүлнэ.

1.1.7. УИХ, Засгийн газраа сөрж биш хуулийн хүрээнд нэг бодлого, нэгдмэл үйл ажиллагаатай хамтран ажилладаг улс төрийн соёлыг хэвшүүлнэ.

1.1.8. Төрийн бодлого, шийдвэрт иргэдийн шууд оролцоог хангаж, иргэний нийгмийн байгууллагын тухай хуулийг санаачилна.

1.1.9. Улс төрийн намуудын шинэчлэлийг гүнзгийрүүлж, ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэн, санхүүжилтүг шилэн болгох улс төрийн нам, улс төрийн намын санхүүжилтүн тухай хуулиуд санаачилна.

#### Өндөр ёс зүйтэй, мэргэшсэн төрийн алба

1.1.10. Улс орныг хөгжилд хөтлөх чадамжтай, зөв бүтэц, зохион байгуулалттай төрийн албыг төлөвшүүлж, “Сайн засаглал”-ыг бэхжүүлнэ.

1.1.11. Төрийн албаны хүний нөөцийн чадамжийг нэмэгдүүлж, мэдлэг, чадвар, ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулж, хууль дээдэлдэг, ард түмэндээ үйлчилдэг болгох иж бүрэн шинэтгэл хийнэ.

## **Авлигагүй улс**

1.1.12. Шударга ёсны үзэл санааг нийгмийн үнэт зүйл болгон хэвшүүлж, авлига, албан тушаалын гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлагыг чангатган, улс үндэстнээрээ авилгаас анgid байх хатуу зарчмыг тогтоосон хууль санаачилан хэрэгжүүлнэ.

1.1.13. Төр засгийн аль ч шатны албан тушаалтан оффшор дансанд хөрөнгө, мөнгө хадгалахыг хориглох эрхзүйн орчныг бий болгоно.

## **Баялгийн шударга хуваарилалт**

1.1.14. Байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчмын дагуу уул уурхайгаас олох өгөөжийг баялгийн болон хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулан иргэн бүрд тэгш, шударга хүртээх бодлогыг Засгийн газарт чиглэл өгч, туштай дэмжиж ажиллана.

1.1.15. Тансаг хэрэглээний татварыг нэмэгдүүлэх, өндөр орлогод их, бага орлогод бага татвар ногдуулах тогтолцоо бий болгохыг дэмжинэ.

## **Шударга, хараат бус шүүх**

1.1.16. Шүүх, прокурорыг улс төр, бизнесийн бүлэглэлийн сонирхлоос анgid байлган, шударга бусын хонгилыг нурааж, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг сэргээнэ.

1.1.17. Эрх мэдэлтэн, эд хөрөнгөтөнд зөвлөн, эгэл ардад хатуу ханддаг завхралыг засч, хүн бүрт хууль тэгш үйлчилдэг зарчмыг хэрэгжүүлнэ.

## **Цахим Монгол**

1.1.18. Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг бүрэн цахимжуулж, тэгш хүртээмжтэй, хүнд суртал, дарамт чирэгдлээс анgid байлгах “Цахим үндэстэн” бодлогыг дэмжинэ.

## **1.2. ИРГЭНДЭЭ ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ – ШУДАРГА ХУВААРИЛАЛТ**

*“Иргэн баян бол улс баян”*

### **Олон тулгуурт эдийн засаг**

1.2.1. Эдийн засгийг олон тулгууртай болгох, экспортын чиг баримжаатай үйлдвэрлэл хөгжүүлэх, иргэндээ хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг хангах төрийн бодлогыг дэмжиж ажиллана.

### **Хөгжилд хөтлөх бүтээн байгуулалт**

1.2.2. Авто зам, төмөр зам, агаарын тээвэр, эрчим хүч, байгалийн хийн хоолой, үндэсний хиймэл дагуул, холбоо мэдээлэл зэрэг суурь дэд бүтцийг өргөтгэн олон улсын сүлжээнд холбохыг дэмжиж ажиллана.

1.2.3. *“Мянганы төмөр зам”* үндэсний их бүтээн байгуулалтыг санаачлан, хэвтээ болон босоо тэнхлэгийн төмөр замын нэгдсэн сүлжээтэй болгохыг дэмжиж ажиллана.

### **Хүнс экспортлогч улс**

1.2.4. Хүн ардаа эрүүл, аюулгүй хүнсээр бүрэн хангах, мал аж ахуй, газар тариалан, хүнсний үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэх *“Organic хүнс экспортлогч улс”* үндэсний хөтөлбөрийг санаачилж ажиллана.

## **Эрчим хүч экспортлогч улс**

1.2.5. Эх орноо цахилгаан, эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр бүрэн хангаж, Тавантолгой, Шивээ-Овоогийн ДЦС, Эрдэнэбүрэнгийн УЦС байгуулах, Багануур, Улаанбаатарын ДЦС III-ын өргөтгөл, 10 аймгийн дулааны станцын төслийг дэмжиж, Зүүн Өмнөд Азийн сүлжээнд холбон эрчим хүч экспортлогч улс болох бодлогоо дэмжиж ажиллана.

## **Бүтээлч шинжлэх ухаан**

1.2.6. Монгол Улсад аж үйлдвэрийн IV хувьсгалыг амжилттай хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлж, их өгөгдлийг удирдах, боловсруулах технологи, хиймэл оюун ухаан, зүйлсийн интернет, финтек, үүлэн тооцоолол, био, нано технологи, дижитал хөгжлийг дэмжсэн хууль санаачилна. Инновацийн татваргүй, чөлөөт бүс байгуулах бодлогыг дэмжинэ.

1.2.7. Шинжлэх ухаан, инновацийн хүрээлэнгүүдийн үйл ажиллагааг бүтээлч хэлбэрт шилжүүлж, нэгдсэн кластераар зохион байгуулахыг Засгийн газарт чиглэл өгч ажиллана.

## **Олборлолтоос боловсруулалтад**

1.2.8. Уул уурхайн томоохон ордуудыг үндэсний эрх ашигт нийцүүлэн здийн засгийн эргэлтэд оруулна. Алт, зэс, төмөр, нүүрс, газрын тос, газрын ховор элемент зэрэг баялгаа боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн олборлолтоос боловсруулалтад шилжих бодлогыг дэмжинэ.

## **Монгол шатахуун**

1.2.9. “*Монгол шатахуун*” хөтөлбөр хэрэгжүүлж, нефтийн хайгуул, олборлолтыг нэмэгдүүлэн, бензин шатахуунаа эх орондоо үйлдвэрлэхийг дэмжинэ. Газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж дуусган, нефть-химийн аж үйлдвэрийн суурийг тавихад онцгой анхаарч, здийн засгийн аюулгүй байдлыг бэхжүүлнэ.

## **Үр өгөөжтэй Оюутолгой**

1.2.10. Оюутолгойн гэрээг улсын здийн засаг, ард иргэдэд илүү өгөөжтэй, үр ашигтай болгон өөрчлөх хатуу шаардлага тавьж, Монгол Улсын эрх ашгийг бүрэн хангахын телөө УИХ, Засгийн газартай хамтран ажиллана. “*Дубайн гэрээ*”-г хүчингүй болгох чиглэлээр УИХ, Засгийн газартай хамтарч ажиллана.

## **Буянт малын үр шим**

1.2.11. Уламжлалт нүүдлийн мал аж ахуйн давуу талыг эрчимжсэн мал аж ахуйн ололт амжилттай хослуулан загварчлан хөгжүүлэх, “*Хөдөө аж ахуйн хорооолол*”-ын бодлогыг дэмжинэ. “*Малчны хотноос үйлдвэрийн цехэд*” хөтөлбөр санаачлан, стандартын шаардлага хангасан түүх эд бэлтгэн нийлүүлэх тогтолцоог төрийн бодлогоор дэмжиж ажиллана.

1.2.12. Малын гаралтай түүхий здийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, импортыг орлох, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх “*Хөнгөн, хүнсний үйлдвэрлэлийн цогцолборууд*”-ыг сэргээн байгуулах ажлыг дэмжинэ.

1.2.13. Малын удмын сан, сүргийн бүтцийг сайжруулж, үржил селекцийн ажлыг шинэ түвшинд гаргах эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Бэлчээр усжуулах, худаг

гаргах, малын тэжээлийн тариалалт, үйлдвэрлэл, хангамжийг өргөтгөх ажлыг төрийн бодлогоор дэмжинэ.

#### **Эрчимжсэн газар тариалан**

1.2.14. Газар тариалангийн усжуулалт, эрчимжүүлэлт, хөрс хамгаалалт, үр сортын ажлыг сайжруулан “*Амар IV аян*”-ыг өрнүүлж, тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх бодлогыг дэмжиж ажиллана.

#### **Төрөлжсөн аялал жуулчлал**

1.2.15. Нуудэлчдийн өв соёл, зан заншил, түүх уламжлал, унаган байгальд түшиглэсэн төрөлжсөн аялал жуулчлалыг хөгжүүлж, үндэсний хөгжлийн бие даасан тэргүүлэх салбар болгох бодлогыг дэмжиж ажиллана.

#### **Үндэсний баялаг бүтээгчид**

1.2.16. Иргэд, хувийн хэвшил, бизнес эрхлэгчдэд олгож буй зээлийн хүүг нэг оронтой тоонд барих, баялаг бүтээгчдэд дарамтгүй, хүртээмжтэй санхүү, мөнгөний бодлогыг дэмжиж ажиллана.

1.2.17. Үндэсний үйлдвэрлэл, баялаг бүтээгчдээ дэмжих “*Эх оронч худалдан авалт*” хөтөлбөр санаачилна.

#### **Ковидгүй Монгол**

1.2.18. Ковид-19 цар тахлыг богино хугацаанд даван туулах, эдийн засгаа хурдтай сэргээх Засгийн газрын хөтөлбөрийг тууштай дэмжиж, нягт хамтран ажиллана.

1.2.19. Ард түмнээ бүрэн вакцинуулж, дархлаажуулах “*Ковидгүй Монгол*” санаачилгыг дэвшүүлж, манлайлж ажиллана. Ковидтой нүүр тулан тэмцэж байгаа эрүүл мэнд, онцгой байдал, цагдаа, мэргэжлийн хяналт зэрэг төрийн албан хаагчдын нийтмийн хамгаалал, урамшууллын бодлогыг онцгой анхаарч Засгийн газарт чиглэл өгч ажиллана.

### **1.3. НАНДИГНАН ДЭЭДЛЭХ ҮНДЭСНИЙ ӨВ СОЁЛ, ҮНЭТ ЗҮЙЛ**

“Үндэс язгуур, хэл соёлоо  
Үрийн үрд өвлүүлэн бадраа”

#### **Үндэсний хэл – Үнэт зүйл**

1.3.1. Эх хэлний бодлогын хэрэгжилтэд онцгойлон анхаарна. Монгол Улсын уул, ус, газар нутгийн нэрийг уuguул эхээр нь хадгалан хэрэглэж, олон улсын болон үндэсний баримт бичиг, газрын зурагт тусган баталгаажуулна.

#### **Монгол хүн – Монголын баархал**

1.3.2. Монгол хүний үнэ цэнэ, авьяас чадварын үнэлэмжийг дээшлүүлэх бодлого хэрэгжүүлнэ. Төрийн дээд шагналын журмыг шинэчилж, хөдөлмөр бүтээлийг бодитоор үнэлдэг оновчтой тогтолцоо бүрдүүлнэ.

#### **Өв соёлоо – Эх орондоо**

1.3.3. “*Өв соёлоо-Эх орондоо*” уриалга гаргаж, үндэсний соёлын өв, түүхийн сурвалж, археологийн олдвор, урлагийн бүтээлийн үндсэн эх, анхдагч хуулбарыг эх орондоо авч ирэх хөтөлбөр боловсруулна. Дэлхийд тархсан болон

эх орондоо байгаа өв соёлын “**Бүртгэлийн нэгдсэн сан**”-тай болох чиглэлийг Засгийн газарт өгч ажиллана.

1.3.4. Үндэсний өв соёл, урлагийн бүтээл, тэдгээрийн хуулбарыг гадаадад гаргах, худалдан борлуулах үйл ажиллагаатай холбоотой харилцааг хуулиар чангатган зохицуулна.

1.3.5. Түүх соёлын өв, археологи, палентлогийн олдворыг тонон сүйтгэж байгаа үйлдэлтэй хатуу тэмцэж, хүлээлгэх хариуцлагыг чангатгасан хууль санаачилж хэрэгжүүлнэ.

1.3.6. Олон улсын Монгол судлалын байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж өргөжүүлнэ. “**Чингис судлалын олон улсын холбоо**”-г санаачлан байгуулж, өв соёлоо эх орондоо төвлөрүүлэн судлах ажлыг эрчимжүүлэх чиглэл Засгийн газарт өгч, хамтран ажиллана.

1.3.7. Уул ус, овоо тахилга, уламжлалт зан үйлд хүндэтгэлтэй хандаж, төрийн тахилгат хайрханууд, үндэсний бахархалт зүйлсийг дээдлэн хамгаалах зарлиг гаргана.


### **Соёлын бүтээлч үйлдвэрлэл – Үндэсний баялаг**

1.3.8. Монгол туургатны өв соёлыг “**Со лын бүтээлч үйлдвэрлэл**” болгон хөгжүүлэхийг дэмжинэ. Дэлхийд танигдсан соёл, урлагийн Монгол брэндийг хөгжүүлэх “**Со лын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор**” байгуулан, соёлын салбарт эхлүүлсэн их бүтээн байгуулалтаа үргэлжлүүлнэ.

1.3.9. Монгол Улсыг дэлхийн нүүдэлчдийн соёл иргэншлийн төв болгох, дэлхийн монголчуудтай хамтран ажиллах зорилгоор “**Нүүдэлчдийн со л, спортын их наадам**”-ыг эх орондоо тогтмол зохион байгуулах санаачилга гарган, ивээлдээ авч хэрэгжүүлнэ.

1.3.10. Монголын соёлын өвийг дэлхийд хүлээн зөвшөөрүүлэх бодлого хэрэгжүүлж, “**Нүүдэллэх Монгол с, зан үйл**”, “**Говийн хадны зургийн цогцолбор**”, “**Хүннүгийн язгууртны булаш**”, “**Өндөр гэгээн Занабазарын хийц**”, “**Уламжлалт анагаах ухаан**” зэрэг өв соёлоо ЮНЕСКО-гийн биет бус өвийн жагсаалтад бүртгүүлнэ.

1.3.11. Монголын төрт улсын гал голомт Орхон, Тамирын хөндий, их эзэн Чингис хааны өлгий нутаг Хан Хэнтий, олон ястны өлгий Алтай-Саяны түүх, соёлыг гүнзгийрүүлэн судлах, хамгаалах, сэргээн засварлах бодлогыг ивээлдээ авч хэрэгжүүлнэ.



## **2.1. ЭРХЭМЛЭН ХАМГААЛАХ ҮНДЭСНИЙ ЭВ НЭГДЭЛ**

“**Эв эеийг эрхэм болгоно,**  
Эрх чөлөөг эрдэнэ болгоно”

### **Эвтэй Монгол**

2.1.1. Ард түмнийхээ эв нэгдлийг бүх талаар бэхжүүлж, эе эвддэг бус эв нэгддэг байхыг эрхэмлэнэ. Үндэсний язгуур эрх ашиг, хүний эрх, эрх чөлөө

эв нэгдэлд аюул занал учруулж болзошгүй аливаа санаархлыг хатуу хориглоно.

**2.1.2.** Нийгэмд баян хоосны ялгаралд сууринсан талцал хуваагдал үүсч, гүнзгийрэн ужиграхаас сэргийлж, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг баримтлан, ард түмнийхээ эв нэгдлийг бэхжүүлнэ.

### **Итгэлцэл – эв нэгдэл**

**2.1.3.** Иргэдийн үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх, төр засаг, нийгмийн үйл хэрэгт идэвхтэй оролцох боломжийг хангаж, төр, ард түмэн, үндэсний цөөнхийн харилцан итгэлцлийг бүх шатанд бататгана.

**2.1.4.** Улс төр, нийгмийн ээдрээтэй асуудлыг үндэсний хэмжээний зөвшилцөл, ойлголцлын зарчмаар шийдвэрлэж, улс төрийн манлайлал үзүүлж ажиллана.

## **2.2. ҮНДЭСНИЙ ЯЗГУУР ЭРХ АШИГ – АЮУЛГҮЙ БАЙДАЛ**

*“Тулганд дүрэлзэх гал ариун байг,  
Тусгаар тогтнол мөнх байг”*

### **Үндэсний аюулгүй байдал – төрийн ой санамж**

**2.2.1.** Тусгаар тогтнол, эдийн засаг, үндэсний түүх, соёл иргэншил, байгаль орчин, монгол хүний аюулгүй байдлыг чухалчлан анхаарч, учирч болзошгүй аюул занал, эрсдэл, сорилтоос сэргийлэн хамгаална.

**2.2.2.** Үндэсний аюулгүй байдлын Үзэл баримтлал, холбогдох хууль, тогтоомжийг үндэсний язгуур эрх ашигт нийцүүлэн шинэчилнэ. **“Монгол хүний аюулгүй байдал”, “Эдийн засгийн аюулгүй байдал”, “Эм, хүнсний аюулгүй байдал”** хөтөлбөрүүд санаачлан боловсруулна.

**2.2.3.** **“Үндэсний аюулгүй байдлын мэдээллийн нэгдсэн сан”** бүрдүүлэн, Монгол төрийн ой санамжийг бэхжүүлж, кибер аюулгүй байдлыг хангах тухай хууль санаачилна.

### **Нэгдмэл удирдлагатай зэвсэгт хүчин**

**2.2.4.** Батлан хамгаалах салбарын эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэн, аливаа аюултай тэмцэх үндэсний чадамжийг нэмэгдүүлнэ. Зэвсэгт хүчин, төрийн цэргийн бусад байгууллагын төрийн захирагааны удирдлагын нэгдмэл байдлыг бий болгож, орон нутгийн хамгаалалтын цэгтэй тогтолцоог бүрдүүлнэ.

**2.2.5.** Хил хамгаалалтын чадавхийг дээшлүүлэн, хилийн цэргийн байгууллагыг төгөлдөржүүлж, улсын хилийн халдашгүй дархан байдал, хилийн зурvasын хамгаалалт, инженерийн байгууламжийг шинэчилж, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангана.

**2.2.6.** Онцой байдлын албаны үүрэг гүйцэтгэх чадварыг эрс сайруулж, гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэмцэх үндэсний чадамжийг дээшлүүлнэ.

### **Монгол цэрэг – энхийн цэрэг**

**2.2.7.** Батлан хамгаалах салбарын энхийг эрхэмлэсэн гадаад бодлогыг туштай үргэлжлүүлэн, НҮБ-ын энхийг сахиулах болон хүмүүнлэгийн бусад

ажиллагаанд идэвхтэй оролцохыг зорино. Зэвсэглэл, техникийг үе шаттайгаар шинэчлэн, цэргийн зориулалттай зарим төрлийн бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх бодлого баримтлана.

2.2.8. Цэргийн албан хаагчдын нийгмийн хамгааллыг олон улсын жишигт хүргэж, офицер, ахлагч нарыг орон сууцаар бүрэн хангах “**Цэргийн хотхон**” хөтөлбөр боловсруулна.

#### **Цэргийн алба – иргэний төлөвшил**

2.2.9. Цэргийн анги, салбарыг залууст эх оронч үзлээр хүмүүжих, бие бялдраа хөгжүүлэх, сэтгэлийн хат тэнхээтэй болох, тодорхой мэргэжил эзэмших, хүний хөгжлийн орчин, иргэний төлөвшлийн сургууль болгон хөгжүүлж, цэргийн дүрмийн бус харилцаа, дэгийг арилгана.

2.2.10. Цэрэг-иргэний хамгаалалтын болон их, дээд сургуулийн цэргийн хэргийн сургалт, бэлтгэлийн уламжлалыг сэргээж, “**Хөдөлмөр, батлан хамгаалахад бэлэн**” хөдөлгөөн өрнүүлнэ.

### **2.3. ХӨГЖИЛД ХӨТЛӨХ НЭГДМЭЛ ГАДААД БОДЛОГО**

“Монгол төрийнхөө алтан аргамжааг бэхэлнэ,  
Монгол хэмээх нэрийг ертөнцийн чихнээ дуурсгана.”

#### **Гадаад бодлогын залгамж чанар**

2.3.1. ОХУ, БНХАУ-тай сайн хөршийн найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлээ батжуулан хөгжүүлж, “Гуравдагч хөрш” орнууд, олон улсын байгууллагуудтай өрнүүлж буй харилцааны эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

2.3.2. Олон улс, бүс нутгийн харилцаанд гарч буй өөрчлөлт шинэчлэл, зөрчил сөргөлдөөнд анхааралтай хандаж, үндэсний ашиг сонирхлыг дээдлэн эвлэрлийг эрхэмлэгч байх идэвх санаачлагатай гадаад бодлого хэрэгжүүлнэ.

#### **НҮБ дахь оролцоо, хувь нэмэр**

2.3.3. НҮБ болон олон талт хамтын ажиллагаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн оролцоог идэвхжүүлнэ. Хүн төрөлхтөн дайны эсрэг оюун санаа, сэтгэлгээний дархлаа тогтоох зорилгоор есдүгээр сарын 2-ныг “**Хүн төрөлхтөн дайныг ялсан өдөр**” болгон тэмдэглэх санаачилга дэвшүүлнэ.

#### **Олон улс дахь Монгол Улсын нэр хүнд**

2.3.4. Олон улсын тавцанд Монгол Улсын нэр хүндийг улам өндөрт өргөне. Монгол Улсын нэр хүндийг нэмэгдүүлэх ардчилал, хүний эрх, засаглал, хэвлэлийн эрх чөлөө, жендер, авилга, бизнес эрхлэлт, аз жаргалын үзүүлэлтийг цаашид нэг ч байраар ухраахгүй, ахиулан ажиллана.

#### **Хөгжлийг дэмжих гадаад бодлого, санаачилга**

2.3.5. Ази, Европыг холбосон газар зүйн байршлын давуу тал, төрийн бодлогын залгамж чанараа хадгалан тээвэр, худалдаа, үйлчилгээний зангилаа - “**Транзит Монгол Улс**” болох зорилтыг дэвшүүлж ажиллана.

2.3.6. Гадаадын хөрөнгө оруулалтыг түүштэй дэмжин, харилцан ашигтай, Монгол Улсын эрх ашигт нийцсэн “Хөгжилд хөтлөх хөрөнгө оруулалт” үзэл баримтлалыг санаачлан боловсруулж, Засгийн газарт чиглэл өгч ажиллана.

#### **Иргэнд хүрсэн гадаад бодлого**

2.3.7. “Хүчирхэг монгол паспорт” хөтөлбөр хэрэгжүүлж, үндэсний гадаад паспорттой иргэдийн визгүй зорчдог орны тоог хоёр дахин нэмэгдүүлнэ.

2.3.8. Гадаадад сурч, ажиллаж, амьдарч байгаа иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах зорилтот арга хэмжээг өргөтгөнө. Тэдний үр хүүхдүүд эх хэлээ сурч, уламжлалт ёс заншлаа өвлөн хадгалахыг дэмжинэ. Эх орондоо ирэх, суралцах, амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.3.9. Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэд, харьяатын асуудлаарх хууль, тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулна.

#### **Эрүүл мэндийн дипломат үйл ажиллагаа**

2.3.10. Дэлхий нийтэд сорилт болсон цар тахал, гамшгийн эрсдэлтэй тэмцэх хамтын ажиллагааг тэлж, эрүүл мэндийн дипломат бодлого, үйл ажиллагааг хөгжүүлнэ.

#### **Соёл, хүмүүнлэгийн дипломат үйл ажиллагаа**

2.3.11. Үндэсний соёл, ёс заншил, өв түүхээ ардын болон сонгодог урлаг, кино, рок поп, спорт, хүмүүнлэгийн бүх хэлбэрээр дамжуулан гадаадад сурталчлах ажлыг эрчимжүүлнэ.

#### **Мэргэшсэн дипломат алба**

2.3.12. Цахим дипломат бодлого хэрэгжүүлнэ. Дипломат төлөөлөгчийн газрууд тэргүүнгүй удаан хугацаанд ажиллаж байгаа гажуудлыг бүрэн арилгана.

2.3.13. Дипломат албаны мэргэжил, ур чадварын шаардлагыг дээшлүүлж, сахилга, ёс зүйн хэм хэмжээг чангатган, алдаа, дутагдал гаргавал заавал хариуцлага хүлээлгэдэг байх зарчмыг түүштэй хэрэгжүүлнэ.

## **ГУРАВ. ХӨГЖИЛ ДЭВШИЛ**

### **3.1. МОНГОЛ ХҮН – МОНГОЛЫН БАЯЛАГ**

“Улсын үндэс газар,  
Улсын баялаг иргэн”

#### **Өрсөлдөх чадвартай боловсрол**

3.1.1. Монгол хүн бүрийг чанартай боловсрол эзэмших тэгш боломжоор бүрэн хангаж, эх оронч сэтгэлтэй, зөв хандлагатай, өрсөлдөх чадвартай, бүтээлч иргэн болгон хөгжүүлэх бодлогыг дэмжинэ.

3.1.2. Боловсролын тогтолцоо, сургалтын хөтөлбөрийг тогтвортой байлгах, сургуулийн орчныг хотхоны хэлбэрээр хөгжүүлэх, малчин өрхийн хүүхдийн боловсролд онцгой анхаарна.

3.1.3. Эх хэл, бичгийг бага сургуульд бүрэн эзэмшүүлсний дараа, дэлхийн “Хоёр гадаад хэл”-ийг ерөнхий боловсролын дунд, ахлах анги болон коллеж, их, дээд сургуульд сургах хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлнэ.

3.1.4. Монгол Улсын дээд боловсролын чанарыг олон улсын жишигт ойртуулж, “Судалгааны их сургууль”-ийг хөгжүүлж, гадаадын оюутан, судлаачийн тоог нэмэгдүүлэн боловсролын экспортыг дэмжинэ.

#### **Хүртээмжтэй эрүүл мэнд**

3.1.5. Монгол Улсын иргэн бүрийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эрт оношилгоонд жилд нэг удаа тэгш хамруулдаг тогтолцоог бүрдүүлнэ. Эрүүл мэндийн үйлчилгээ, эмчилгээг дэлхийн жишигт хүргэн, Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэн, эрүүл мэндийн экспортыг нэмэгдүүлэх бодлогыг дэмжинэ.

3.1.6. “Эрүүл – эх, нялхас” үндэсний хөтөлбөр санаачлан боловсруулж, төрөх эмнэлгүүдийн орчин нөхцлийг дэлхийн түвшинд нийцүүлж сайжруулах чиглэлийг Засгийн газарт өгч ажиллана. Эх, нялхсын эрүүл мэндийг онцгойлон анхаарна.

3.1.7. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, иргэдээ чийрэгжүүлэх зорилгоор “Эрүүл чийрэг монгол хүн” хөдөлгөөн өрнүүлнэ.

3.1.8. Хүн амаа өсгөх, удмын сангаа хамгаалах бодлогыг тууштай баримталж, олон хүүхэдтэй гэр бүлийг төрийн бодлогоор дэмжих зарлиг гаргана.

#### **Залуучууд – Монголын ирээдүй**

3.1.9. “Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль”, “Залуучуудын Үндэсний хөтөлбөр”-ийг шинэчлэн боловсруулж, төрөөс залуучуудын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлнэ.

3.1.10. Инноваци, бүтээлч байдал, шинэ үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуй эрхлэх ур чадвар (энтрепренер), гарааны бизнес (старт апп) эрхлэлт, хөдөлмөрийн хөлсийг шударгаар үнэлэх бодлогыг дэмжиж ажиллана.

3.1.11. “Орлоготой оюутан” тусгай хөтөлбөр санаачилж, оюутан, залуусын хөдөлмөр эрхлэх боломж, цагаар ажиллах ажлын байрны тоог нэмэгдүүлэх үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

3.1.12. Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд нэн шаардлагатай, дутагдаж байгаа, тэргүүлэх чиглэлийн мэргэжлээр суралцах оюутан, залуусын сургалтын төлбөрийг төрөөс бүрэн хариуцдаг тогтолцоонд шилжих хууль санаачилна.

3.1.13. Эх орныхоо 330 сум, нийслэлийн хороодоос тус бүр нэг шилдэг сургачийг шалгаруулж, дэлхийн шилдэг 100 их, дээд сургуульд суралцуулах Ерөнхийлөгчийн нэрэмжит “XXI зууны монголын ирээдүй - 2100 оюутан” хөтөлбөрийг санаачлан ажиллана.

3.1.14. Хүүхэд, залуусын дунд “Номын сайн нөхөр” хөдөлгөөн өрнүүлж, ном унших соёл, дадлыг түгээн дэлгэрүүлнэ.

3.1.15. Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл, бие бялдрын өв тэгш хүмүүжил олгох “Дөл”, “Шонхор” хөтөлбөрийг сэргээн хэрэгжүүлнэ. “Оюутан цэрэг” хөтөлбөрт хамрагдах их, дээд сургуулийн эрэгтэй оюутны тоог нэмэгдүүлэх, сайн дурын үндсэн дээр эмэгтэй оюутныг хамруулах бодлого хэрэгжүүлнэ.

3.1.16. Дотоод, гадаадын их, дээд сургуулийн шинэ төгсөгчдийг төрийн албанад ажиллах тэгш боломж олгох хууль эрхзүйн орчин бүрдүүлнэ.

3.1.17. Залуу гэр бүл, залууст зориулсан “Залуус хороолол”-ыг Улаанбаатар хот, аймгийн төвүүдэд байгуулах чиглэлийг Засгийн газарт өгч ажиллана.

#### **Халамжаас хөдөлмөрт**

3.1.18. “Халамжаас хөдөлмөрт” бодлого хэрэгжүүлж, иргэдийн ажлын байр, орлогыг нэмэгдүүлэх талаар Засгийн газарт чиглэл өгч ажиллана.

3.1.19. Мэргэжлийн боловсрол, сургалтыг үндэсний бүтээн байгуулалт, ажлын байр, ажил олгогчдын эрэлтэд нийцүүлэн хөгжүүлэх “Шинэ зууны баялаг бүтээгч” хөтөлбөр санаачлан хэрэгжүүлнэ.

#### **Ядуурлаас ангид Монгол өрх**

3.1.20. Ажилгүйдлыг бууруулах хүрээнд ажлын байр нэмэгдүүлж, чинээлэг дундаж давхаргыг хүн амын зонхилох хэсэг болгоход чиглэсэн ядуурлыг бууруулах цогц бодлого боловсруулна.

3.1.21. Ажилтай, орлоготой өрх бүрийг орон сууцтай болгох, олон хүүхэдтэй гэр бүлд нэн тэргүүнд хөнгөлөлт үзүүлэх “Өрх бүрт орон сууц” хөтөлбөрийг санаачилна.

#### **Зорилтот дэмжлэг – эznээ олсон халамж**

3.1.22. Хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд зөв хүн болон төлөвших нөхцлийг бүрдүүлэх, хүүхдийн нийгмийн хамгааллын бодлогыг тогтвортой байлгах, хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх “Бүхнийг хүүхдийн төлөө”uriалга гаргаж ажиллана.

3.1.23. Жендерийн тухай хэвшмэл ойлголт, хандлагыг өөрчлөх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах асуудлыг анхааралдаа авч Засгийн газарт чиглэл өгнө.

3.1.24. Ахмадуудын насны хишиг, нийгмийн хамгаалал, тэтгэврийн шинэчлэлийн бодлогыг дэмжиж, “Ахмадын хотхон”-үүд байгуулах талаар Засгийн газарт чиглэл өгч ажиллана.

3.1.25. Ахмад настныг ажиллуулж, тэдний туршлага, ур чадварыг залуу үед өвлүүлэх бодлогыг дэмжиж ажиллана.

3.1.26. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай хуулийг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, барилга байгууламж, нийтийн тээвэр, гудамж, зам талбайг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй болгохыг шаардаж ажиллана.

#### **Эрсдэлгүй Монгол өрх**

3.1.27. Архидалт, хар тамхи, донтолт зэрэг нийгмийн сөрөг үзэгдлээс урьдчилан сэргийлж, хатуу тэмцэх хүрээнд “Эрсдэлгүй Монгол өрх” хөтөлбөр санаачлан хэрэгжүүлнэ. Архины хатуулгийг бууруулахыг шаардаж ажиллана. Хар тамхины худалдаа, хэрэглээг таслан зогсоож, хуулийн хариуцлагыг эрс чангатгана.

3.1.28. Угийн бичиг, удмын түүхээ хөтөлдөг уламжлалыг сэргээн, цус ойртолт, хүн амын удмын сангийн аюулгүй байдлыг хангах зарлиг гаргаж хэрэгжүүлнэ.

9006109  
9019120396

## 3.2. НОГООН ХӨГЖИЛ – МОНГОЛЫН ИРЭЭДҮЙ

“Өвөг дээдсийн өвлүүлж үлдээсэн газар шороо  
Үр хойчис голомтоо тулах амин нутгаа хайрлай”

### **Газар, бэлчээр – амьдралын үндэс**

3.2.1. Малын бэлчээр, тариалангийн газрын зохистой ашиглалт, менежментийг сайжруулж, бэлчээрийн доройтол, цөлжилттэй тэмцэх, нөхөн сэргээх ажлыг төрийн бодлогоор дэмжинэ.

### **Ус – чандмань эрдэнэ**

3.2.2. “Эх оронч гол” хөтөлбөр хэрэгжүүлэн хур тунадас, гадаргын ус хуримтлуулах томоохон усан сан, хөв, далан, дамжуулах хоолой байгуулан, тал хээр, говийн бүсийг усжуулах, гүний усаа хэмнэх бодлогыг дэмжиж ажиллана.

### **Ой мод, амьтан, ургамал – эх орны баялаг**

3.2.3. Монгол орны байгалийн тэнцвэрт байдал, экосистем, ой мод, ховор ургамал, амьтны төрөл зүйлийг хамгаалах, өсгөн үржүүлэх, нөхөн сэргээх ажлыг дэмжиж, “Монголдоо мод тарья” хөдөлгөөн өрнүүлнэ.

### **Хариуцлагатай уул уурхай**

3.2.4. Техник технологийн дэвшлийг шингээсэн, байгал орчинд хор хөнөөлгүй, эдийн засгийн хувьд харилцан ашигтай, монгол хүний оролцоог хангасан, ил тод хариуцлагатай уул уурхайг дэмжинэ.

3.2.5. Хариуцлагагүй уул уурхайн үйл ажиллагаанаас бий болсон байгаль орчны доройтол, бохирдлыг арилгах, хууль бусаар олгогдсон лицензүүдийг цуцлах, байгалийг нөхөн сэргээх, хамгаалах, хохирол учруулагчид хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалтыг чангатгах чиглэлээр холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулна.

### **Байгаль эх – ногоон үйлдвэрлэл**

3.2.6. Байгальд ээлтэй, хаягдалгүй, эдийн засгийн хувьд үр ашигтай ногоон дэд бүтэц, мал аж ахуй, газар тариалангийн нөхөн сэргээгддэг үйлдвэрлэл, сэргээгдэх эрчим хүч зэрэг эко “Ногоон хөрөнгө оруулалт”-ын цогц төслийг санаачлана.

### **Эх дэлхий – Та бидний гэр**

3.2.7. Монгол эх орныхоо газар нутгийн хуурайшилт, цөлжилт, хөрсний доройтолтой тэмцэх ажилд иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог идэвхжүүлнэ. Дэлхийн дулаарагал, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах олон улсын хүчин чармайлтад Монгол Улсын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ.

### **Цэвэрхэн Монгол**

3.2.8. Хөдөө орон нутаг, хот, суурин газрын хогийг иргэд, олон нийтийн оролцоотойгоор бүрэн цэвэрлэж, эх нутаг, байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах “Цэвэрхэн Монгол”uriалга гаргаж орон даяар хэрэгжүүлнэ.

### 3.3. ХОТ, ХӨДӨӨ – ХӨГЖЛИЙН ТЭНЦВЭР

“Төрөлх хотдоо тухтай амьдаръя,  
Төрсөн нутагтаа жаргаж сууя”

#### A. Найрсаг хотууд – Улаанбаатар, Дархан, Эрдэнэт

##### Эрүүл, цэвэр хотууд

3.3.1. Хотуудын агаарын бохирдлыг 80 хувь бууруулах, гэр хорооллын хөрсний бохирдлыг багасгах, хог, хаягдлыг дахин боловсруулах байгальд ээлтэй үйлдвэрүүд байгуулахыг дэмжиж, Засгийн газарт чиглэл өгч ажиллана.

##### Ногоон хотууд

3.3.2. Хотдоо мод тарьж, зүлэгжүүлэлт хийсэн иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулж, айлын хашаа, зуслангийн бүс, орон сууцны хотхон бүрт “Бичил ногоон орчин” бүрдүүлэх хөдөлгөөн санаачилж өрнүүлнэ.

3.3.3. Улаанбаатар хотын Туул, Сэлбэ, Улиастай, Баянгол, Түргэний гол, Дархан хотын Хараа, Зулзагын гол, Эрдэнэт хотын Эрдэнэт, Говил, Зун, Хангалын голын дагуу иргэд амралт, чөлөөт цагаа ая тухтай өнгөрүүлэх цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжууд барих санаачилга гаргана.

##### Түгжрэлгүй хотууд

3.3.4. Хотуудын авто замын түгжрэлийг арилгах зорилгоор давхар зам, гүүрүүд, нийтийн тээврийн олон төрөлт, ухаалаг сүлжээг барьж байгуулах

“Түгжрэлгүй хотууд” цогц төсөл санаачлан, дэмжиж ажиллана.

3.3.5. Дархан цаазат Богдхан уулыг тойрсон “Богдхан төмөр зам”-ыг барьж, Улаанбаатар хотод төмөр замын гармыг цөөлөх бодлогыг дэмжиж ажиллана.

3.3.6. Хотуудын орон сууцны хотхон, гэр хорооллын гудамж талбай, орц, гарцыг чөлөөтэй нэвтэрдэг болгох, тэдгээрийн доторх замуудыг шинээр нэмж барихыг дэмжиж, оршин суугчдын тав тухыг алдагдуулсан аливаа үйлдлийг таслан зогсоо чиглэлийг Засгийн газарт өгч ажиллана.

3.3.7. Хот суурин газарт олон улсын стандартад нийцсэн явган, дугуйн замын сүлжээ, автомашингүй гудамжуудыг шинээр байгуулахыг санаачлан, Засгийн газарт чиглэл өгч ажиллана.

##### Олон төвт хотууд

3.3.8. Улаанбаатар хотын хэт төвлөрлийг задалж, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотод олон төвт суурьшлын бүс, хаяа, дагуул хот, суурингууд байгуулах, “Налаих, Багануур, Багахангай”-г өргөжүүлэн хөгжүүлэхийг төрийн бодлогоор дэмжинэ.

3.3.9. Зүүн хойд Азийн агаарын зам, төмөр замын зангилаа болсон “Шинэ Зуун мод – Аэросити” хот байгуулахыг тууштай дэмжинэ.

3.3.10. Эрдэнэт хотыг шинэ төлөвлөлтөөр хөгжүүлж, “Инноваци, цахим, технологийн үндэсний загвар хот” болгохыг дэмжиж ажиллана.

9000109  
9019120 596

3.3.11. Дархан хотыг металлургийн хүнд аж үйлдвэр, арьс, шир боловсруулах, хөнгөн, хүнсний үйлдвэрлэлийн цогцолбор бүхий “Орчин үеийн аж үйлдвэрийн хот” болгож эрчимтэй хөгжүүлэхийг дэмжиж ажиллана.

### Б. Хөдөө нутаг – хөгжлийн тулгуур

#### Бүсчилсэн хөгжил – тогтвортой ирээдүй

3.3.12. Бүсчилсэн хөгжлийг эрчимжүүлэх, шинэ үзэл баримтлалаар дэмжих хууль санаачилна. Бүс нутгийн эдийн засгийн төрөлжилтийг нэмэгдүүлэх эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, хөнгөн, хүнсний үйлдвэр, уул уурхайн боловсруулах хүнд аж үйлдвэрүүдийг дэмжинэ.

3.3.13. Баруун, Хангайн, Төвийн, Зүүн бүс бүрт үйлдвэрлэл, технологийн парк, тээвэр логистикийн төв бүхий “Үндэсний кластер”-үүд байгуулах, чөлөөт бүсүүд хөгжүүлэх бодлогыг дэмжин ажиллана.

3.3.14. Аймгийн төвүүдийг орон нутгийн хотууд болгон хөгжүүлнэ. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд аймгуудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх “Аймаг бүрт – Жишиг бүтээн байгуулалт” хөтөлбөр санаачилж, Засгийн газарт чиглэл өгч ажиллана.

3.3.15. Аймаг, сум хооронд сайжруулсан, хатуу хучилттай зам барих “Нутгийн зам” төслийг эрчимжүүлж, “Мянганы зам”-ын магистрал сүлжээнд холбох ажлыг дэмжиж ажиллана.

#### Бүс нутаг – чадварлаг хүний нөөц

3.3.16. Бүсчилсэн хөгжилтэй уялдуулан орон нутаг дахь их дээд сургууль, коллеж, МСҮТ-ийг хөгжүүлэх бодлогыг дэмжиж ажиллана.

3.3.17. Бүс нутгийн томоохон бүтээн байгуулалтыг нарийн мэргэжлийн хүний нөөц, ажиллах хүчээр хангах бодлогын хүрээнд МСҮТ-үүдийг хөгжүүлэх тусгай хөтөлбөр санаачлан Засгийн газарт чиглэл өгч ажиллана.

#### Орон нутаг – брэнд үйлдвэрлэл

3.3.18. Алслагдсан бүс нутаг, аймаг, сумдад томоохон аж ахуйн нэгжүүд салбараа нээх, инновацад суурилсан шинэ үйлдвэр байгуулахыг хүү багатай чанартай хүнсний бүтээгдэхүүнээр тогтмол, аюулгүй, найдвартай хангах бодлогын хүрээнд улсын хэмжээнд зоорь, хүлэмж, агуулахын аж ахуйг хөгжүүлэх зээл, татварын хөнгөлөлт, хөрөнгө оруулалт, импортын бүтээгдэхүүнээс хамгаалах бодлогоор дэмжинэ.

3.3.19. Хот, орон нутгийн иргэдийг эх орныхоо экологийн цэвэр, хямд, чанартай хүнсний бүтээгдэхүүнээр тогтмол, аюулгүй, найдвартай хангах бодлогын хүрээнд улсын хэмжээнд зоорь, хүлэмж, агуулахын аж ахуйг хөгжүүлэх “Органик хүнсний зоорь” хөтөлбөрийг санаачлан Засгийн газарт чиглэл өгч ажиллана.

3.3.20. Байгальд ээлтэй нүүдлийн мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг эрсдлийн даатгал, бүртгэл, мэдээлэлд суурилсан ухаалаг системтэй холбон, тогтвортой хөгжүүлэх “Эрсдэлгүй ХАА” хөтөлбөрийг санаачлан, дэмжиж ажиллана.

3.3.21. Орон нутгийн брэнд бүтээгдэхүүнээр хот суурин газрын хэрэглэгчдийг хангах, хотын бүтээгдэхүүнийг хямд үнээр орон нутагт шуурхай, чанартай хүргэх “Онлайн худалдаа”-г дэмжиж ажиллана.

### **Миний нутаг – тавтай амьдрал**

3.3.22. Аймаг, сумын төвд цэвэр, бохир ус, дулааны шугам, мэдээлэл холбооны сүлжээг өргөтгэн хөгжүүлж, төрөлх нутаг, төрсөн сумандaa тав тухтай амьдрах боломжийг бүрдүүлэх “*Шинэ хөдөө*” төсөл хэрэгжүүлэх чиглэлийг Засгийн газарт өгнө.

3.3.23. Алслагдсан бүс нутгийн иргэдэд нэмэгдэл олгох, хөдөө орон нутгийн иргэдэд орон сууцны хөнгөлөлт, ипотекийн зээл олгох бодлогыг эрчимжүүлнэ.

3.3.24. Хот суурин газраас орон нутагт шилжин суурьших иргэдийг нийгэм, эдийн засгийн цогц бодлогоор дэмжиж, хөдөлмөрлөх, бизнес эрхлэх, ая тухтай амьдрах бүхий л таатай нөхцлийг бүрдүүлэх “*Нутагтаа сайхан амьдаръя*” хөдөлгөөн өрнүүлж ажиллана.